



БАТЛАВ
"АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦЛАТ КОМПАНИЙН ЗАВХАН
АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН ДАРГА

Г.БАДЛАМХАТАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 07/20

2020 он 02 сар 10 өдөр

Улиастай сум

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	Хүсэлтийн дугаар:	№
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	Цэцэн-Уул сумын Цэцэрлэг, 9038426
1.3	Хэрэглэгчийн байршил:	Завхан аймаг Цэцэн-Уул сум, 5-р баг Цагаан нуур-2 213 тоот
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1/ Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн албан хүсэлт 2/ Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн №000005754 гэрчилгээ.
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Тооцооны бүрэн чадал:	64 кВт

Хоёр. Холболтын цэг:

2.1	Цэцэн-Уул сумын төвд байрлах 15/0,4кВ-ын АТП-01 дэд станцын 1-р гаргалгааны №07-р шонгоос холбож авах.
-----	--

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Барилга доторхи 0,4 кВ талын ерөнхий оруулгад DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур, 5А-ийн тоолуур, гүйдлийн трансформатор, ачаалалд тохирсон автоматыг тусгай хайрцагт суурилуулах.
-----	---

Дөрөв. Тусгай шаардлага:

4.1	АТП-01 дэд станцын 0,4кВ-ын ерөнхий шитний 1-р гаргалгааны №01-07-р тулгуур хүртэл АС-35 утасыг СИП-50 маркийн утсаар бүрэн солих.
4.2	АТП-01 дэд станцын хүчний трансформатор нь 100кВА чадалтай тул 250кВА хүчний трансформатораар шинэчилж солих. Хүчний трансформатор нь 250кВА болж байгаатай холбогдуулан чадалд тохирсон шит шинээр тавигдах ба 4-н гаргалгаатайгаар тоноглож тоноглолуудын ачаалал даах чадварыг тооцоогоор сонгож авах.

- 4.3 Дэд станцад суурилуулж буй тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ тоноглол байх, $\pm 10\%$ -ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх.
- 4.4 Хэрэглэгчийн ерөнхий цит нь автомат, рубильник, Вольтметр, Амперметр зэргээг тоноглож монтажилах ба цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс хүчдэлийн хэлбэлзэл, хэт ачаалал, богино залгааны гүйдэл, фаз бүрэн бус үед, хэт хүчдэлээс хамгаалах төхөөрөмж тавьж тоноглолыг хамгаалах.
- 4.5 Цахилгаан хангамжийн II зэрэглэлийн шугамнаас холбогдож байгаа тул цахилгаан эрчим хүчний нөөц эх үүсгэвэртэй байх.
- 4.6 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бүт сөсний сэргээн засварлах.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар хууль дүрмийг мөрдөх:


- 5.1 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь "Алтай Улиастайн Эрчим Хүчний Систем" төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай.
- 5.2 Дэд өртөө болон шугамын "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
- 5.3 Цитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
- 5.4 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнга үзлэг шалгалт хийж хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.
- 5.5 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.
- 5.6 "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.10-ийн дагуу түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах.
- 5.7 "Эрчим хүчний тухай" 30.1.12.эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө хариуцах. Хэрэглэгч уг эвдрэл, гэмтлийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй.
- 5.8 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.13.нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барьж байгаа учир шинээр барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх.
- 5.9 Угсралтын ажлын явцад тус компанийн харьяасалбар, алба хэлтэсээрхяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
- 5.10 Өргөтгөл хийсэнтэй холбогдуулан буугдсан тоног төхөөрөмжүүдийг "АУЭХС" ТӨХК-ийн Завхан аймаг дахь салбарын хөрөнгөнд бүртгүүлж хүлээлгэн өгөх.
- 5.11 Техникийн нөхцөлд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23, 4.24-р заалт, Систем компанийн дотоод журмын заалтын дагуу шугам сүлжээнд холбоно.

Зургаа. Бусад

6.1

Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 2 жилийн хугацаанд хийж, гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.


Хянасан: Ахлах инженер



Б.Лхагвадорж

Техникийн нөхцөл гаргасан:

АЗАлбаны дарга



Г. Нямдэмбэрэл

БАТЛАВ.
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ТӨХХК
ЗАВХАН АЙМГИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.ДАМДИНБАЗАР

Техникийн нөхцөл

2020-02-11.

Дугаар: ТН-20/09

Улиастай сум

Захиалагч байгууллага: ЦЭЦЭН-УУЛ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ

Хэрэглэгчийн нэр: ЦЭЦЭН-УУЛ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ

Харилцах утас:

Байршил:

ЦЭЦЭН-УУЛ СУМ

Холбооны хэрэгцээ:

(урьдчилсан тооцоогоор)

Телефоны тоо (ширхэгээр)

Интернет хэрэглэгчийн тоо

Техникийн онцгой нөхцөл: Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу физик болон шилэн кабель татах техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээ явуулах зорилготойгоор кабель татсан тохиолдолд тухайн барилгыг техникийн болон улсын комисс хүлээц авахгүй болно.

Техникийн үндсэн нөхцөл:

1. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Цэцэн-Уул сумын салбарын дэргэдэх оруулгын баганаас P1, P2, P3 бэлэн баганаар дамжуулан татаж 3-р баганаас цааш P4, P5 баганыг шинээр босгож дамжуулан барилгын оруулгын Нишээр техникийн өрөөнд оруулна.
2. Холбооны байранд болон Шинэ барилгын техникийн өрөөнд FDF байрлуулан цэнэглэнэ.
3. Холбооны кабель шугам, дэд бүтцийн угсралт суурилуулалтыг Харилцаа холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай.

Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:

1. Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх
2. Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй, хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж төсөв зурагт оруулах.
3. Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон суурилуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах

Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

4. Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Завхан аймгийн газрын ШК-ийн инженерээр (утас: 70462815, 95954605) хянуулан баталгааг авсан байх.

5. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ ШК-ийн инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж, хүлээн авах ажлын актан д хавсаргах
6. Угсралтын газар шорооны ажил эхлэхийн өмнө хотын инженерийн шугам сүлжээний техникийн ашиглалт хариуцдаг мэргэжлийн байгууллагуудад трассын зургийг хянуулан зөвшөөрөлцсөн байх.
7. Кабель шугамын угсралт болон газар шорооны ажлыг эхлэхдээ Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний Завхан аймгийн газрын ерөнхий инженерээс зөвшөөрөл авч харъяалагдах ШК-ийн инженерийн хяналтан дор гүйцэтгэнэ.
8. Угсралтын ажлыг гадна агаарын температур -5 градусаас илүүгүй хүйтний нөхцөлд гүйцэтгэх
9. Шинээр татсан кабель болон FDF-д тэмдэглэгээг бүрэн хийсэн байх
10. Угсралтын ажлын явцад захиалагч, ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хянуулсан байх
11. Хэрэглэгч холбох нөхцлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол Улсын стандарт MNS 5471:2005 ерөнхий шаардлагын дагуу хийгдсэн тохиолдолд гадна холбооны угсралтын ажлыг хүлээж авна.

Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:

Шинээр хийгдсэн холбооны худаг сувагчлал болон кабель шугам нь интернетийн сүлжээнд холбогдох тул:

12. Танай эдэлбэр газарт суурилуулагдсан холбооны сувагчлал болон кабелийг гадны механик гэмтлээс хамгаалах
13. Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах
14. Худаг сувагчлалд техник ашиглалтыг хоногийн ямар ч үед шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах

Шаардлагатай материал:	а) Агаарын шилэн кабель	-250м
	б) FDF /	- 2ш
	в) Агаарын багана	-2ш
	г) Баганын тулгуур	-1ш
	д) Төмөр бетон хөл	-3ш
	е) Кабелийн зуувч	-5ш

Техникийн нөхцлийг Цэцэн-Уул сумын Цэцэрлэгийн эрхлэгчийг хавсран гүйцэтгэгчийн 2019 оны 12 сарын 16-ны өдрийн 05 тоот албан хүсэлтийг үндэслэн 2020 оны 02 дүгээр сар 11-ний өдөр олгов.

Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт, шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Завхан аймгийн газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.

Энэхүү техникийн нөхцөл нь олгогдсон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.

Техникийн нөхцлийг
боловсруулсан:

ШК-ийн инженер
...../С.Шаарийбуу/

Техникийн нөхцлийг
хянасан:

Ерөнхий инженер
...../Ц.Эрдэнэсайхан/